БАТЛАВ.
СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ

# СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 06 Улаанбаатар хот

| Д/д | | Хяналт, шалгалтын зорилт, үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамрагдах нэгж | Хугацаа | Хамтран хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтан | Үр дүн, шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. ЗАХИРГАА УДИРДЛАГА, ДОТООД АЖЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 1. | 1.1. | Захиргааны зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх. | Захиргаа, удирдлагын газар | Бүтэн жилээр | Архив-бичиг хэргийн эрхлэгч | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд, чанарын өндөр түвшинд хэрэгжүүлж, биелэлтийг бүрэн тайлагнасан байна. |
| 2. | 1.2. | Хариутай бичгийн шийдвэрлэлт, erp.e-mongolia.mn программын үйл ажиллагаанд хяналт тавих, Үндэсний төвийн захиралд танилцуулж холбогдох арга хэмжээ авах. | Захиргаа, удирдлагын газар | Улирал бүрээр | Архив-бичиг хэргийн эрхлэгч | Хариутай болон хариугүй бичгийн шийдвэрлэлтэд хугацаа хэтрүүлэхгүй байх, албан хэрэг хөтлөлтийн чанар дээшилсэн байна. |
| 3. | 1.3. | Байгууллагын шилэн дансны хөтлөлтөд хяналт тавьж ажиллах, хугацаа хоцроож мэдээлсэн мэдээллийн шалтгаан нөхцөлийг тодруулж удирдлагад танилцуулах. | Захиргаа, удирдлагын газар | Улирал бүр | Ерөнхий нягтлан бодогч | Шилэн дансны тухай хууль, МУЗГ-ын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай тогтоолын хэрэгжилт бүрэн хангагдана. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4. | 1.4. | 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 4 арга хэмжээний биелэлт болон бусад зөрчилгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажиллах. | Захиргаа, удирдлагын газар | Улирал бүрээр | Ерөнхий нягтлан бодогч | 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 4 арга хэмжээний биелэлтийг хангаж, бусад зөрчилгүй ажилласан байна. |
| 5. | 1.5. | Үндэсний төвийн "Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025 оны төлөвлөгөө"-ний биелэлтийг хангуулж ажиллах, хяналт тавих. | Нийт албан хаагчид | Жилээр | Хүний нөөцийн ажилтан | Төлөвлөгөөний биелэлтэд тавих хяналтыг сайжруулж, албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийн байдалд эерэг үзүүлэлт гаргасан байна. |
| 6. | 1.6. | Албан хэрэг хэрэг хөтлөлтийг Монгол бичгээр давхар хөтлөх, үйл ажиллагаанд бүх албан хаагчид оролцож сурч байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах. | Нийт албан хаагчид | Жилээр | Архив, бичиг хэргийн эрхлэгч | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. |
| 7 | 1.7 | Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээний чанар аюулгүй байдалд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулж ажиллах. | Үйлчилгээ, аюулгүй байдлын алба | Жилээр | Үйлчилгээ, аюулгүй байдлын албаны дарга | Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангагдаж, харуул хамгаалалтын үйлчилгээнд гарах эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан байна. |
| **ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЯВУУЛАХ ДОТООД ХЯНАЛТ** | | | | | | |
| 9. | 2.1. | ХАБЭА-н талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих хариуцсан албан хаагчтай хамтран ажиллах. | Нийт албан хаагчид | Жилээр | ХАБЭА хариуцсан ажилтан | ХАБЭА-н тухай хууль болон холбогдох дүрэм журмын биелэлтийг хангаж осолгүй ажлын байрыг бий болгоно. |
| 10. | 2.2. | Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд тайлагнах. | Бүх газар, нэгж | Хагас, бүтэн жилээр | Захиргааны мэргэжилтэн | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сайжирч тайлангийн чанар дээшилнэ. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11. | 2.3. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулах. | Захиргаа, удирдлагын газар | Бүтэн жилээр | Захиргааны мэргэжилтэн | Үндэсний төвийн захирлын 2024 оны А/15 тушаалаар батлагдсан “Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам”-ын хэрэгжилт бүрэн хангагдана. |
| 12. | 2.4. | Байгууламжийн үйл ажиллагаа, цахилгаан хангамж, аюулгүй байдалд үзлэг шалгалт явуулж, удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээ авах. | Захиргаа, удирдлагын газар | Бүтэн жилээр | Үйлчилгээ, аюулгүй байдлын албаны дарга | Үндэсний Их баяр наадам болон бусад бүх нийтээр амрах баярын болон тэмдэглэлт өдрүүдэд хариуцлагатай жижүүр байнга ажиллуулах, барилга байгууламжийн дэд бүтцийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА А.ГАНБАТ

БОЛОВСРУУЛСАН:
ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
АЖИЛТАН Г.АНХСАНАА